


ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАР 2014 ОНД

2014 онд аймгийн Эрүүл мэндийн салбарын төр, хувийн хэвшил, нөхөрлөлийн 61 байгууллагад 1082 ажилтан албан хаагчид ажиллаж байгаагийн 844 буюу 78 хувь нь эмэгтэйчүүд эзэлж байгаа бөгөөд их эмч 182, сувилагч 279, эмнэлгийн дунд мэргэжилтэн (тусгай, техникийн г.м) 279, үүнээс эх баригч 36, багийн эмч 68, лаборант 32 ажиллаж, 10 000 хүн амд ноогдох их эмч 22.2 болж өнгөрсөн оны мөн үеийнхээс 1.4, эмнэлгийн дунд мэргэжилтэн 66.6 болж 3.1 хувиар тус тус өссөн дүнтэй байна.




Аймгийн хүн амын тоо 2006 оноос тасралтгүй буурч байсан бол 2013 оноос өсөх хандлага ажиглагдаж байна.


Хүн амын $\text{a} \text{b} \text{c} \text{d} \text{e} \text{f} \text{g} \text{h} \text{i} \text{j} \text{k} \text{l} \text{m} \text{n} \text{o} \text{p} \text{q} \text{r} \text{s} \text{t} \text{u} \text{v} \text{w} \text{x} \text{y} \text{z}$ нь тухайн орон нутгийн нийгэм эдийн засгийн байдал, эрүүл мэндийн гол хэмжүүр болдог билээ.




2014 онд Ховд аймгийн хүн амын дундаж наслалт 71.1 болж улс, аймгуудын түвшнээс дээгүүр буй нь хүн ам зүйн бодлого зохих түвшинд байгааг харуулж байна.




Ховд аймагт төрөлт тогтвортой хадгалагдаж, нас баралт доогуур байгаа нь хүн амын цэвэр өсөлтөд эерэгээр нөлөө үзүүлж байна.




Ховд аймагт эхийн эндэгдэл 2014 онд 100 000 амьд төрөлтөнд 86.2 байгаа нь 1990 оныхоос 4 дахин, 2000 оныхоос 2.4 дахин буурсан хэдий ч эндэгдэл тогтвортой буурахгүй улсын дунджаас дээгүүр байна.




Ховд аймгийн 5 хүртлэх насны хүүхдийн эндэгдэл 2014 онд 1000 амьд төрөлтөнд 20.2 байгаа нь 1990 оныхоос 5 дахин, 2000 оныхоос 2.2 дахин буурч ч Мянганы зорилтыг хангах **боломжтой** байна.



Ховд аймгийн нялхсын эндэгдэл 2014 онд 1000 амьд төрөлтөнд 19.2 байгаа нь 1990 оныхоос 3.3 дахин, 2000 оныхоос 1.8 дахин буурсан хэдий ч Мянганы зорилтыг хангахад **илүү чанартай үйлчилгээг** үзүүлэх шаардлагатай байна



Ховд аймагт халдварт өвчин сүүлийн жилүүдэд нэмэгдэж байгаа хэдий ч улсын дунджаас доогуур байна.



Эрүүл мэндийн салбарын санхүүжилт 2004 оноос 6 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байна

ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ ЖИЛИЙН ХҮРЭЭНД



“Эх хүүхдийн эрүүл мэндийг сайжруулахад дэмжлэгт удирдлагуудын оролцоо”, “Эх хүүхдийн эндэгдлийг бууруулахад сувилахуйн тусламж үйлчилгээг сайжруулах нь” аймгийн зөвлөгөөнүүд, “Эх, хүүхдийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулахад багийн эмчийн оролцоо” бүсийн зөвлөлдөх уулзалтуудыг санаачлан зохион байгуулснаар эх хүүхдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулахад орон нутгийн салбар хоорондын үйл ажиллагааг сайжруулахад үр дүнгээ өглөө.

АЙМГИЙН ХҮН АМЫН ДУНДАЖ НАСЛАЛТ УЛС, АЙМГУУДЫН ДУНДЖААС ДЭЭГҮҮР БАЙНА.



Ховд аймагт төрөлт нэмэгдэн, нас баралт буурч, шилжилт хөдөлгөөний зохистой харьцаа бий болсноор хүн ам зүйн бодлого хэвийн түвшинд хадгалагдаж, дундаж наслалт 71.1-д хүрсэн нь улс, аймгуудын түвшингээс дээгүүр байна.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВҮҮД ШААРДЛАГАТАЙ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖӨӨР ХАНГАГДЛАА.



Орон нутгийн хөгжлийн сангийн 61.9 сая төгрөгөөр бүх сумдын Эрүүл мэндийн төвүүдийг ургийн доплер, пульсоксиметр, зүрхний цахилгаан бичлэгийн аппарат, гал тогооны цахилгаан иж бүрэн тоног төхөөрөмж, зарим сумдад хүчил төрөгч



өтгөрүүлэгч, шарлагын аппарат зэргээр хангаж, суурин даралтын аппаратуудыг өрх, сумын эрүүл мэндийн төвүүдэд олгов.

БОЭТ-Д ЦАХИМ ЭМНЭЛЭГ ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖИЖ АМАРЖИХ ГАЗАРТ ХАЛААЛТЫН ШИНЭ ТЕХНОЛОГИ НЭВТРҮҮЛЭВ.



БОЭТ-ийн цахим үйлчилгээг өргөжүүлэн өрөө тасалгааг камержуулж, онлайн сургалтын өрөөг тохижуулахад 25 сая, Амаржих газрын төрөх, нярай, мэс заслын өрөөний халаалт тавих, нярайн инкубатор авахад зориулж 13.7 сая төгрөгийг орон нутгаас шийдвэрлэв.



“ЭРҮҮЛ ГУДАМЖ-МИНИЙ ХАШААНААС” АЯН ЗОХИОН БАЙГУУЛАВ



“Эрүүл гудамж-Миний хашаанаас” аяныг Жаргалант сумын Цамбагарав, Буянт, Бичигт багуудад зохион байгуулж, нийт өрхийн 97 хувь нь хашааны хаалгаа бүрэн хээлж, хаягжуулсан, 72 хувь нь хашаагаа будаж, шохойдон өнгөлж, 40 хувь нь стандартын шаардлага хангасан бие засах газар, бохирын цооногтой болж, тэгшлэх шаардлагатай гудамжны 75 хувийг зассан бөгөөд орон нутгийн хөгжлийн сангаас 13 сая, нийт 46.5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлжээ.

ГАДААДЫН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖИЙН БАГИЙНХАН ИРГЭДЭД ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЛЭЭ

Хамтран ажиллах гэрээний дагуу Америкийн нүдний, Францын түлэнхийн, Австралийн эмэгтэйчүүдийн дурангийн мэс заслын эмч нарын багийнхан аймагт ажиллаж баруун бүсийн 589 иргэдэд үзлэг хийж, 155 хагалгааг алслагдсан бүс нутгийн иргэдэд үнэ төлбөргүй хийлээ.



АЙМГУУДААС АНХ УДАА ХОВД АЙМАГТ ВИРУСОЛОГИЙН ЛАБОРАТОРИ БАЙГУУЛАГДАВ



Дэлхийн банкны 140 сая төгрөгийн санхүүжилтээр БОЭТ-д вирусологийн лаборатори байгуулагдсанаар халдварт өвчин судлалын төвд илгээж хариу авдаг байсан тогтолцоо үгүй болж вирусын халдварын шинжилгээг орон нутагтаа хийх боломж бүрдлээ.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДОВТОЛГОО АРГА ХЭМЖЭЭ ЗОХИОН БАЙГУУЛАВ

Иргэн бүрд эрүүл мэндийн боловсрол олгох, зөв дадал хэвшилтэй болгох зорилготой “Эрүүл мэндийн довтолгоо” арга хэмжээг аймгийн 26541 өрхөд бодитойгоор хүргэж 31152 иргэнийг мэдээлэл, сурталчилгаанд хамруулсан нь иргэдийн эрүүл мэнддээ хяналт тавих, эрт эмчилгээ, оношилгоонд хамрагдахад үр дүнгээ өгсөн бөгөөд орон нутгийн хөгжлийн сангаас 19.6 сая төгрөгийн дэмжлэг (унаа, томиллолт, эм урвалж г.м) үзүүлэв.



ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВҮҮДИЙН САНХҮҮЖИЛТЭНД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЛЭЭ

2014 онд өрхийн Эрүүл мэндийн төвийн санхүүжилтийн хүрэлцээгүй байдалд анхаарч аймгийн Засаг даргын нөөцөөс тус бүр 5 сая, Жаргалант сумын орон нутгийн хөгжлийн сангаас тус бүр 7 сая төгрөг, нийт 60 сая төгрөг олгосон нь өрхийн эрүүл мэндийн төвүүдийн үйл ажиллагааг хэвийн явуулахад түлхэц өгчээ.



БҮСИЙН ОНОШИЛГОО ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ХАЛААЛТ САЙЖИРЛАА

БОЭТ, Амаржих газрын гаднах шугам сүлжээг шинэчлэн дулаан халаалт, хэрэгцээний халуун, хүйтэн усны босоо болон хэвтээ 295 метр шугамын хоолойг шинээр хийж, доторх шугам сүлжээний тодорхой хэсгийг шинэчлэн, зарим тасгуудад шинээр пар нэмж байрлуулснаар халаалт өмнөх оныхоос сайжирлаа.

ХАВДРЫН ХӨНГӨВЧЛӨХ ЭМЧИЛГЭЭНИЙ ӨРӨӨГ ТОХИЖУУЛЖ АШИГЛАЛТАНД ОРУУЛАВ

Бүсийн оношилгоо эмчилгээний төвд “Итгэл хавдаргүй Монгол” үндэсний сангаас хөнгөвчлөх эмчилгээний 2 өрөөг 13.6 сая төгрөгийн 25 нэр төрлийн тоног төхөөрөмж багаж хэрэгслийг байршуулан тохижууллаа.



САЛБАРЫН ХЭМЖЭЭНД НЭВТРҮҮЛСЭН ШИНЭ ТЕХНОЛОГИ



БОЭТ-ийн мэс заслын эмч нар ходоодны хорт хавдрыг ходоод тайрах болон бүтнээр авах хагалгааг нэг удаагийн оёгч аппаратыг анх удаа ашиглан орчин үеийн техникээр бие даан амжилттай хийлээ.

Мөн гэмтлийн улмаас тархинд цус хурсан, яаралтай мэс засал эмчилгээ хийхгүй бол амь насанд аюул учрах үйлчлүүлэгчид гэмтлийн мэс заслын эмч Д.Цэрэнбадам, мэс засалч эмч Ж.Ганхуяг нар гавал ясанд терпонаци хийж, цус хуралтыг авах мэс заслыг амжилттай хийж, амь насыг аварсан нь шинэ дэвшилтэт эмчилгээ байлаа.




Нүүр амны гажиг заслын эмчилгээг шинээр нэвтрүүлж нийт 41 хүнд авагддаггүй аппарат, 16 хүүхдэд авагддаг аппарат суулгалаа.

Нярайн түнхний үений ЭХО аппаратаар зөвхөн нярайн тасагт шинэ төрсөн нярайг оношилдог байсан бол энэ онд 1 аппарат нэмэгдүүлж амбулаторийн тасагт байрлуулан дүрс оношилгооны 2 эмчийг сурган баруун бүсийн хэмжээнд оношилгоо хийж давтан үзлэгт хамруулах боломжтой боллоо.



Хэвлийн урд ханын болон цавины эвэрхийг “ETHICON” брэндийн тороор нөхөх, архаг

парапроктитын цоргыг лигатурын аргаар, хүүхдийн фимоз өвчний “Церкумцези” хагалгааг тээрхийн арьсыг тэлэх ажилбараар хийх шинэ технологиудыг нэвтрүүлэв.



ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРТ 2015 ОНД ХИЙГДЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ДЭВШҮҮЛСЭН ЗОРИЛТ

а) 2015 онд аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар:

- Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн яаралтай тусламжийн машин шинэчлэхэд 50 сая
- Зооноз өвчин судлалын хээрийн лабораторийн машин авахад 25 сая
- Сумдын багийн эмч нарын унаа шинэчлэхэд 40 сая
- Зооноз өвчин судлалын төвд тусгай хамгаалалтын (Эбола) хувцас хэрэгсэл (30ш хувцас) авахад 3.5 сая

НИЙТ

118.5 сая

б) 2015 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө, төсөл хөтөлбөрийн арга хэмжээгээр

- Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн гудамж талбайн тохижилт 150.0 сая
- Нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөр төсөл арга хэмжээ 10.0 сая
- Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг бэхжүүлэх төсөл хөтөлбөр 5.0 сая
- “Амны хөндийн эрүүл мэнд” хөтөлбөр төсөл арга хэмжээ 5.0 сая

НИЙТ

170.0 сая

в) 2015 онд улсын төсөв, төсөл хөтөлбөр хандивлагч байгууллагын дэмжлэгээр

| | |
|---|------------------------|
| • Булган сумын Нэгдсэн эмнэлгийн барилга шинээр барих (Улсын төсөв) | 1339.1 сая – 384.5 сая |
| • Манхан сумын Спорт цогцолборын барилга (Улсын төсөв) | 2118.0 сая - 788.8 сая |
| • Дуут сумын ЭМТ-ийн засвар (ГХАН-ийн “Эрчим хүчний үр ашиг төсөл) | 130.0 сая |
| • Үенч сумын ЭМТ-ийн өргөтгөл (Японы Өвсний үндэс хөтөлбөр) | 174.6 сая |
| • БОЭТ-ийн тоноглогдсон машин (Улсын төсөв) | 156.3 сая |
| • БОЭТ-ийн Бельгийн төсөл (Улсын төсөв) | 8700.0 сая - 500 сая |

НИЙТ

12157.1 - 2134.2сая

г) Эрүүл мэндийн чиглэлээр 2015 онд дэвшүүлсэн зорилт:

“Эрүүл эхээс эрүүл хүүхэд” зарчмыг эмнэлгийн тусламж, үйлчилгээний бүх шатанд хэрэгжүүлэн, эх хүүхдийн өвчлөл, эндэгдлийг бууруулж, Мянганы хөгжлийн зорилтыг хангана.

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлж, эрүүл мэндийг дэмжигч байгууллага, өрхийг дэмжих хөдөлгөөнийг өрнүүлнэ.

Бүсийн оношилгоо эмчилгээний төвийг Монгол, Бельгийн Засгийн газрын чадавхжуулах төсөлд хамруулж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, эмч мэргэжилтнүүдийг сургана.

Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг дэмжиж төр, хувийн хэвшлийн оролцоог хангаж ажиллана.

Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг бэхжүүлэх хөтөлбөрийг үргэлжлүүлж сумдын эрүүл мэндийн төвийн оношилгоо, эмчилгээ, тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

Зарим сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн усан хангамжийг сайжруулах, цэвэр бохир усны сүлжээнд холбох арга хэмжээг дэс дараатайгаар шийдвэрлэнэ.

Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Зооноз өвчин судлалын төв, зарим сумдын түргэн тусламжийн машиныг шинэчилнэ.

Зарим сум, өрхийн эрүүл мэндийн төвийн засвар хийж, Буянт өрхийн эрүүл мэндийн төвийг төвлөрсөн халаалтын системд холбож, Бугат, Рашаант өрхийн эрүүл мэндийн төвийг цахилгаан халаалтад шилжүүлнэ.

Зоонозын өвчин судлалын төвд шаардлагатай тоног төхөөрөмж, хамгаалалтын хувцас хэрэглэл нийлүүлж, Жаргалант суманд эмнэлгийн ороох, боох материалын үйлдвэр байгуулна.

Эрүүл мэндийн санхүү, төсөв:

Аймгийн эрүүл мэндийн салбар нь 2014 онд улсын төсвөөс 11908,5 сая төгрөгийн төсөвтэйгөөр үйл ажиллагаагаа явуулж байсан бол 2015 онд 12800,8 сая төгрөгийн төсөв батлагдаж төсөв урьд оныхоос 7,5 хувиар нэмэгдсэн дүнтэй байна. Нийт төсвөөс эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээнд тухайлбал сумын эрүүл мэндийн төвд 3443,2 сая төгрөг, өрхийн эрүүл мэндийн төвд 480,8 сая төгрөг хуваарилагдсан нь нийт эрүүл мэндийн салбарын төсвийн 30,6 хувийг эзэлж байна